



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/44/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оргилмөрөн Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.09.15 № 80
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ГАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2023 оны санхүүгийн тайлангийн хугацаанд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 370,629.1 мянган төгрөг үндсэн дансанд, нэмэлт дансаар 15,000.0 мянган төгрөгийг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтэд бүрдүүлэн зардлын зүйл ангиар зарцуулж хэмнэлтийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбарын зөвлөлийн хөрөнгөөс 6,290.0 мянган төгрөгийг сумын цагдаагийн хэсэгт ашигладаг суудлын автомашины засварт, 3,880.0 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,976,000.00</u>	<u>836,000.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,976,000.00	836,000.00
351	Түүхий эд материал	836,000.00	836,000.00
35110	Тусгай зориулалттай материал	836,000.00	836,000.00
354	Хангамжийн материал	2,140,000.00	0.00
35410	Бичиг хэргийн материал	350,000.00	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,790,000.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>65,761,105.62</u>	<u>50,039,604.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	65,761,105.62	50,039,604.99
392	Биет хөрөнгө	65,694,439.06	50,034,049.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,700,000.00	58,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,839,166.51	-37,176,666.47
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,592,300.00	54,592,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,392,914.51	-34,422,354.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,248,600.00	21,248,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,614,379.92	-12,907,829.67
393	Биет бус хөрөнгө	66,666.56	5,555.56
39301	Програм хангамж	375,000.00	375,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-308,333.44	-369,444.44
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>68,737,105.62</u>	<u>50,875,604.99</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>68,737,105.62</u>	<u>50,875,604.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	68,737,105.62	50,875,604.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,307,200.00	11,307,200.00
51101	Өмч: - төрийн	11,307,200.00	11,307,200.00
512	Хуримтлагдсан үр дүн	55,533,134.36	37,671,633.73
51210	Өмнөх үеийн үр дүн	55,533,134.36	55,533,134.36
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-17,861,500.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,896,771.26	1,896,771.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>68,737,105.62</u>	<u>50,875,604.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>316,563,600.00</u>	<u>385,629,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>316,563,600.00</u>	<u>385,629,100.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,250,000.00	15,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,250,000.00	15,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	286,313,600.00	370,629,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	286,313,600.00	370,629,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>318,976,387.84</u>	<u>403,490,600.63</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>318,976,387.84</u>	<u>403,490,600.63</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,428,397.00	387,542,689.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,181,091.16	132,503,201.90
210101	Үндсэн цалин	46,065,887.00	82,040,600.10

210102	Нэмэгдэл	19,510,505.16	40,404,811.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,705,419.82
210104	Урамшуулал	1,604,699.00	4,352,370.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,486,818.70	16,089,552.28
210201	Тэтгэврийн даатгал	9,727,618.70	11,089,040.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,568,500.00	1,304,593.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,384,200.00	1,043,674.41
210204	Ажилгүйдлийн даатгал	346,000.00	240,823.26
210205	Эрүүл мэндийн даатгал	3,460,500.00	2,411,421.19
2104	Хангамж, бараа материалын зардал	22,233,460.00	27,938,300.00
210401	Бичиг хэрэг	3,289,660.00	6,376,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,000,000.00	20,745,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	943,800.00	817,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,540,000.00	31,776,000.00
210604	Урсгал засвар	17,540,000.00	31,776,000.00
2107	Томилолт, зочны зардал	338,000.00	773,900.00
210702	Дотоод албан томилолт	338,000.00	773,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	136,549,390.00	97,575,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,416,710.00	95,710,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	199,030.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,650.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	710,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,099,637.14	80,885,905.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,668,886.00	65,164,405.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,430,751.14	15,721,500.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,547,990.84	15,947,910.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	9,551,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	2,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	6,565,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,547,990.84	6,396,910.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,547,990.84	6,396,910.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-2,412,787.84</u>	<u>-17,861,500.63</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-2,412,787.84</u>	<u>-17,861,500.63</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>323,353,734.00</u>	<u>388,013,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>323,353,734.00</u>	<u>388,013,100.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,250,000.00	15,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,250,000.00	15,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	286,313,600.00	370,629,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	286,313,600.00	370,629,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,790,134.00	2,384,000.00

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,790,134.00	2,384,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>310,565,734.00</u>	<u>388,013,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>310,565,734.00</u>	<u>388,013,100.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>289,227,609.16</u>	<u>369,681,189.18</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,181,091.16	132,503,201.90
210101	Үндсэн цалин	46,065,887.00	82,040,600.10
210102	Нэмэгдэл	19,510,505.16	40,404,811.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	5,705,419.82
210104	Урамшуулал	1,604,699.00	4,352,370.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,493,428.00	16,089,552.28
210201	Тэтгэврийн даатгал	9,734,228.00	11,089,040.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,568,500.00	1,412,309.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,384,200.00	935,957.90
210204	Ажилгүйдлийн даатгал	346,000.00	240,823.28
210205	Эрүүл мэндийн даатгал	3,460,500.00	2,411,421.19
2104	Хангамж, бараа материалын зардал	22,271,600.00	27,588,300.00
210401	Бичиг хэрэг	3,327,800.00	6,026,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,000,000.00	20,745,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	943,800.00	817,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,330,000.00	29,986,000.00
210604	Урсгал засвар	19,330,000.00	29,986,000.00
2107	Томилолт, зочны зардал	338,000.00	773,900.00
210702	Дотоод албан томилолт	338,000.00	773,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	136,549,390.00	97,575,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,416,710.00	95,710,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	199,030.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,650.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	710,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,064,100.00	65,164,405.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,064,100.00	65,164,405.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>21,338,124.84</u>	<u>18,331,910.82</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,790,134.00	11,935,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,790,134.00	2,384,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	2,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	6,565,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,547,990.84	6,396,910.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,547,990.84	6,396,910.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,788,000.00</u>	<u>0.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>12,788,000.00</u>	<u>0.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>12,788,000.00</u>	<u>0.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	12,788,000.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	12,788,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-12,788,000.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	57,945,922.20	71,149,893.46
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	57,945,922.20	71,149,893.46
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,412,787.84	-2,412,787.84
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	55,533,134.36	68,737,105.62
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	55,533,134.36	68,737,105.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	55,533,134.36	68,737,105.62
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-17,861,500.63	-17,861,500.63
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	37,671,633.73	50,875,604.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,629,100.00	364,232,189.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,629,100.00	364,232,189.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,064,100.00	354,681,189.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,586,200.00	132,503,201.90
210101	Үндсэн цалин	107,593,600.00	82,040,600.10
210102	Нэмэгдэл	19,942,600.00	40,404,811.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,050,000.00	5,705,419.82
210104	Урамшуулал	0.00	4,352,370.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,698,300.00	16,089,552.28
210201	Тэтгэврийн даатгал	11,354,800.00	11,089,040.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,335,900.00	1,412,309.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,068,700.00	935,957.90
210204	Ажилгүйдлийн даатгал	267,200.00	240,823.28
210205	Эрүүл мэндийн даатгал	2,671,700.00	2,411,421.19
2104	Хангамж, бараа материалын зардал	24,043,100.00	23,588,300.00
210401	Бичиг хэрэг	4,026,000.00	4,026,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,747,500.00	18,745,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,269,600.00	817,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,700,000.00	23,696,000.00
210604	Урсгал засвар	23,700,000.00	23,696,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,190,000.00	773,900.00
210702	Дотоод албан томилолт	1,190,000.00	773,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,682,000.00	92,865,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,000,000.00	91,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,040,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	115,830.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	720,000.00	710,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,164,500.00	65,164,405.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,164,500.00	65,164,405.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,565,000.00	9,551,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,565,000.00	9,551,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	2,986,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,565,000.00	6,565,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,629,100.00	364,232,189.18
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	370,629,100.00	364,232,189.18
132001	Орон нутгийн төсвөөс	370,629,100.00	364,232,189.18
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.50	6.50
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2.50	2.50
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7.50	7.50
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	2.00	2.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.50	1.50
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,000,000.00	15,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,000,000.00	15,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,000,000.00	15,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,000,000.00	4,000,000.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,290,000.00	6,290,000.00
210604	Урсгал засвар	6,290,000.00	6,290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,710,000.00	4,710,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,710,000.00	4,710,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,000,000.00	15,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,000,000.00	15,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 5,432.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,993.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 3,439.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд цалинг алдаатай бодсон, татварын хөнгөлөлтийг давхардуулан эдлүүлсэн, улс төрийн албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэл олгосон зэрэг нийт 1,993.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгаагүй ХХОАТ-ын өмнөх оны өр төлбөрийг тайланд онд барагдуулсан, санхүүгийн тайланд татвартай холбоотой авлага, өр төлбөр тайлагнаагүй байхад татварын тооцооллын үлдэгдлийн тодорхойлолтод зарим татварын нэр төрлөөр авлага, өр төлбөр илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-д "бүх өр төлбөр", Татварын ерөнхий хуулийн 29.1-д "Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ", 29.1.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын тайлангаар үүссэн авлага, өр төлбөрийг татварын төрөл тус бүрээр татварын байгууллагатай тулгаж залруулж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жаргалант сумын ИТХ-д бүртгэлтэй, одоо ашиглагдаж буй 6258ОРО улсын дугаартай Landcruiser 100 маркийн тээврийн хэрэгслийн 2022, 2023 оны АТБӨЯХТ, агаарын бохирдлын төлбөрийг төлөөгүй, тус тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй байна.

Энэ нь Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тайланг татварын албанд ирүүлнэ. Авто тээврийн тухай хуулийн 17.2-д "Техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй авто тээврийн хэрэгслийг /байлдааны тусгай зориулалттайгаас бусад/ замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах, АТБӨЯХТ, агаарын бохирдлын төлбөрийг бүрэн барагдуулж, цаашид хугацаанд нь төлж хэвших.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 210401, 210901, 210806, 210809, 213204, 213209 дансны зардлын бүлэг хооронд нийт 3,439.0 мянган төгрөг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	485.2	1	485.2								
	1	1,508.5	1	1,508.5								
	1	0					1	0				
	1	0					1	0				
	1	3,439.0					1	3,439.0				
Дүн	5	5,432.7	2	1,993.7			3	3,439.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
	НИЙТ	1	1			1				